



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2021 оны 06 сарын 15 өдөр

Дугаар 208

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө нээлттэй дуудлагын
худалдаагаар худалдах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 29 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны “Төрийн өмчийн үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийн дуудлагын худалдааны талаар авах зарим арга хэмжээний тухай” 268 дугаар тогтоолын 4.2, 4.3 дахь заалт, “Мэдээ тайлангийн маягт батлах тухай” 269 дүгээр тогтоолын 2, 3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Аймаг, нийслэлийн анхан болон давж заалдах шатны Шүүхийн Тамгын газруудын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй ашиглалтын хугацаа дууссан, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 6 нэрийн нийт 123,933,526.99 (нэг зуун хорин гурван сая есөн зуун гучин гурван мянга таван зуун хорин зургаан төгрөг ерэн есөн мөнгө) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий автомашинуудыг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдахыг зөвшөөрч, худалдах доод үнийг хавсралтад заасны дагуу тогтоосугай.

2. Монгол Улсын Шүүхийн ерөнхий зөвлөлийн гүйцэтгэх нарийн бичгийн дарга О.Амгаланбаатар, аймаг, нийслэлийн анхан болон давж заалдах шатны шүүхийн Тамгын газруудын дарга нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Төрийн болон орон нутгийн өмчийн газрын төлөөлөгчийг оролцуулан үндсэн хөрөнгийг дуудлагын худалдаагаар худалдах ажлыг холбогдох хууль тогтоомж, захиргааны актын дагуу байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Дуудлагын худалдаанаас олох орлогыг (дуудлагын худалдааны зардлыг хассан дүнгээр) зохих журмын дагуу улсын төсөвт төвлөрүүлэх;

2.3. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.4. Энэ тогтоолын биелэлтийг холбогдох мэдээ тайлангийн маягт, хөрөнгийн үнийг төвлөрүүлсэн баримт, тээврийн хэрэгслийг улсын бүртгэлээс хасуулсан тодорхойлолтыг 2021 оны 3 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

132001453

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2021 оны 26 дугаар сарын 28-ны өдрийн
208 дугаар тогтоолын хавсралт

АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН АНХАН БОЛОН ДАВЖ ЗААЛДАХ ШАТНЫ ШҮҮХИЙН ТАМГЫН ГАЗРУУДЫН
ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, НЭЭЛТТЭЙ ДУУДЛАГЫН ХУДАЛДААГААР ХУДАЛДАХ АВТОМАШИНЫ ЖАГСААЛТ

д/д	Шүүхийн тамгын газруудын нэр	Автомашинны нэр, марк, улсын дугаар	Арлын дугаар	Үйлдвэрлэсэн, ашиглалтад орсон он	Нийт гүйлт (км)	Балансын нийт үнэ, хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Худалдах доод үнэ (төгрөг)
1	Говь-Алтай аймаг дахь шүүхийн тамгын газар	Мицубиши Пикаф-L200 91-18 ГАУ	MMBJNK7403D 043616	2005/2014	205,990	7,700,000.00	2,000,000.00
2	Дорноговь аймгийн Замын-Үүд сумын шүүхийн тамгын газар	Ланд Круйзер-100 03-94 УБЗ	JTECJ09J5055 12082	2006/2006	194,500	61,517,151.00	3,500,000.00
3	Нийслэлийн давж заалдах шатны шүүхийн тамгын газар	Соната-5 04-32 УБЗ	KMHEN41AP4A 072528	2004/2004	147,738	18,225,000.00	700,000.00
4		Соната-6 06-51 УБЗ	KMHET41A9A5 26507	2008/2008	161,975	27,830,000.00	1,500,000.00
5	Өмнөговь аймаг дахь шүүхийн тамгын газар	Соната-5 50-59 ӨМӨ	KMHEN41BP2A 756786	2002/2011	312500	5,000,000.00	700,000.00
6	Багахангай, Налайх дүүргйн шүүхийн тамгын газар	Соната-7 07-64 УНУ	KMHEN41BACA 413085	2012/2012	126,590	3,661,375.99	2,500,000.00
Нийт дүн						123,933,526.99	10,900,000.00
						/нэг зуун хорин гурван сая есөн зуун гучин гурван мянга таван зуун хорин зургаан төгрөг ерэн есөн мөнгө/	/арван сая есөн зуун мянга/